

## ӨГҮҮЛЭЛ

**БНХАУ-ын Зөөлөн хүчний бодлогын  
онцлог ба Монгол Улс****Максимын Хишигтуяа** 

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,  
Улаанбаатар, Монгол Улс  
[khishigtuya\\_m@mas.ac.mn](mailto:khishigtuya_m@mas.ac.mn)

**Хураангуй:** Хятад орон хөгжин хүчирхэгжиж буй нь дэлхий нийтийн анхаарлыг татаж эхэлснээр энэ өсөлт хөгжлөөс айх, болгоомжлох хандлага ч их болсон. Иймд Хятад улсыг дэлхий дахинд илүү сайн ойлгуулж танин мэдүүлэх, Хятадын өсөлтөөс айх хэрэггүй гэдгийг сурталчлах шаардлага тулгарснаар зөөлөн хүчний бодлого эрчимтэй явуулж байна. Хятад Улс зөөлөн хүчний бодлогод “соёл”-ыг онцлон олон мянган жилийн түүхтэй өвөрмөц соёл болон Хятадын онцлогтой марксист соёлын үзэл санаа, ололт амжилтыг сурталчлахыг Хятадын зөөлөн хүчний бодлогын онцлог гэж үзжээ. Энэ өгүүлэлд Хятадын соёлын зөөлөн хүчний бодлогын гол стратеги болох “Соёлын гадагш гарах” стратегийн тухай товч дурдаж, хятад хэлний боловсрол, хэвлэл мэдээлэл, кино урлаг зэрэг салбарыг соёлын дипломат ажиллагааны арга хэрэгсэл болгон ашиглаж байгаа байдал ба Монгол Улсад энэ бодлого хэрхэн хэрэгжиж байгааг дээрх гурван салбарын хүрээнд авч үзэв.

**Түлхүүр үг:** Хятад улс, соёлын зөөлөн хүч, гадагш гарах стратеги, хятад хэл, хэвлэл мэдээлэл, кино урлаг

**Удиртгал**

Орчин үеийн олон улсын ашиг сонирхлоо хэрэгжүүлэх зөөлөн харилцааны чиг хандлага нь бусад хүчний бодлогоор илрэх болж, их бага улс орнуудын олон нийтийн санаа хэмжээгээр зөөлөн хүчний бодлого бодолд нөлөөлөх замаар үндэсний хэрэгжүүлж байна. Манай улсад ОХУ,



БНХАУ, АНУ, Япон, БНСУ, БНТУ, БН Казахстан<sup>1</sup> зэрэг улс хил залгаа байдал, түүхэн холбоо харилцаа, улс төрийн үзэл баримтлал зэрэг учир шалтгааны улмаас зөөлөн хүчний бодлогоо явуулж байгаа ба нөгөө талаас манай орон ч зөөлөн хүчний бодлого явуулах хэрэгтэй талаар судлаачид зөвлөсөөр байна. Зөөлөн хүчний бодлого нь улс орнуудын гадаад бодлогын нэг хэсэг тул үүнийг эсэргүүцэх хязгаарлах боломжгүй байдаг.

Онолын хувьд зөөлөн хүчний бодлогын тодорхойлолт олон байдаг ч соёл, улс төрийн үзэл суртал, гадаад бодлогын талаар зөв дүр төрх бүрдүүлж нөлөөлөл үзүүлэх гэсэн тодорхойлолт эдүгээ олон улсад түгээмэл ашиглагдаж байна. БНХАУ эдийн засгийн хувьд хүчирхэгжин дэлхийн их гүрэн болохын хэрээр гадаад дүр төрхдөө анхаарах шаардлага үүссэнээр зөөлөн хүчний бодлого нь гадаад бодлогын гурван тулгуурын нэг болоод байна. 2007 оны ХКН-ын XVII

их хурлын илтгэлд “Өнөө үед соёл нь улс үндэстний эв нэгдэл, бүтээлч байдлын хамгийн чухал эх сурвалж болж улс орны өрсөлдөх чадварын чухал хүчин зүйл болж байна. Иймд улс орны соёлын зөөлөн хүчийг нэмэгдүүлэх хэрэгтэй”<sup>2</sup> гэж зааснаар зөөлөн хүчний бодлого, үйл ажиллагаа албан ёсны бодлого болж эхэлсэн байна. Соёлын зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа болох соёлын дипломат ажиллагаа (cultural diplomacy)-нд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, урлаг, соёлын арга хэмжээ зохион байгуулах, эрдэм шинжилгээний солилцооны хөтөлбөр, гадаадад хэл-соёлын хүрээлэн ажиллуулах зэрэг олон арга хэрэгсэл байдаг. БНХАУ ч эдгээр арга хэрэгслийг өргөн хүрээнд ашиглаж соёлын дипломат ажиллагаа явуулж байна. Энэ өгүүлэлд Хятадын соёлын зөөлөн хүчний бодлогын онцлог, соёлын дипломат ажиллагааны голлох стратеги, Монгол Улсад үзүүлж буй нөлөөллийн талаар өгүүлнэ.

### БНХАУ-ын Зөөлөн хүчний бодлогын онцлог:

“Хүч чадал” гэдэг нь А тал Б-ийн үзэл санаа үйл хөдлөлийг хязгаарлах чадвар, өөрөөр хэлбэл А тал Б-ээр ямар нэг үйлдэл хийлгэх эсвэл үл хийлгэх чадвар юм. Энэ чадварыг олж авах хүч хэрэглэх, мөнгө эд хөрөнгө ашиглах, мэдлэгээ ашиглах гэсэн аргууд байдаг. Гурав дахь нь өөрийн мэдлэг чадварыг ашиглан Б-г бишрүүлэн дагуулах, өөрийн хүслийн дагуу үйлдэл хийхэд

уриалах явдал ба энэ нь зөөлөн хүч болно. Жозеф Найн онолоор зөөлөн хүчний гол эх сурвалжууд нь соёлын татах хүч, улс төрийн үзэл баримтлал, энх тайванч гадаад бодлого гурав болно. Тэгвэл 2000-аад оноос эхлэн Хятад Улсын хувьд эдгээр эх сурвалжаас алийг нь онцлох вэ? Хятадын онцлогтой зөөлөн хүчний бодлого юу байх, зорилго нь ямар

<sup>1</sup> Стратеги судалгааны хүрээлэн, “Их гүрнүүдийн зөөлөн хүчний бодлого Монгол Улс”, *Аюулгүй байдал, стратеги тойм сэтгүүл*, №17, 2023/05

<sup>2</sup> “胡锦涛在中国共产党第十七次全国代表大会上的报告”, 2007年10月25日, <http://src.people.com.cn/>

байх талаар өргөн хүрээнд маргаан мэтгэлцээн өрнөж байв.

Б.С.Глэйзер, М.Э.Мерфи нар зөөлөн хүчний онол Хятадын эрдэмтэд судлаачдын сонирхлыг татах болсон шалтгааныг “*Нэгдүгээрт Хятадын уламжлалт философитой тохирч байсан явдал. Хятадын уламжлалт философид хааны зам (王道) дарангуйлагчийн замыг (霸道) ялна гэж үздэг. Хүч хэрэглэн дарангуйлахаас (霸道) илүүтэй ёс суртахууны хүчинд тулгуурлаж (王道) улсыг удирдахыг сургадаг. Хоёрдугаарт цаг хугацааны хувьд ЗХУ-ын хувь заяанаас зайлсхийж, их гүрэн болох зорилгоор улс үндэстнүүдийн мандал буурлын шалтгааныг судалж байх үед Ж.Найн онол Хятадад нэвтэрсэн явдал*” гэж үзжээ<sup>3</sup>. Зөөлөн хүчний онолын тухай Хятадын судлаачдын дунд хоёр үндсэн чиглэлийн маргаан үүссэн. Нэг нь Хятадын онцлогтой зөөлөн хүчний гол элемент нь “соёл” гэсэн чиглэл байна. Хятад Улсад зөөлөн хүчний тухай анхны өгүүлийг ХКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны байнгын хорооны гишүүн Ван Хунин (王沪宁) Фудан их сургуулийн профессор байхдаа 1993 онд бичжээ. Өгүүлэлдээ “*Зөөлөн хүчний хэмжээ нь түүний тархалтаас хамаарна. Зөвхөн соёл өргөн тархсан үед л зөөлөн хүчийг бий болгож чадна..., .... Нэг төрлийн соёл бусад улс орон, олон*

*улсын хамтын нийгэмлэгийн үндсэн үнэт зүйл, нийтлэг соёл болсон үед тэр соёлыг үүсгэсэн нийгэм аяндаа их хэмжээний зөөлөн хүчтэй болно*”<sup>4</sup> хэмээн соёлыг зөөлөн хүчний гол ойлголт гэж үзжээ. Ван Хунин ба Юй Шиньтянь (俞新天) нар энэ чиглэлийн гол төлөөлөгчид болдог. Нөгөө хэсэг нь зөөлөн хүчний бодлогын гол элемент нь улс төрийн хүч байх ёстой гэж үздэг. Циньхуа их сургуулийн профессор Янь Шюэтуан (阎学通) “*Соёлын хүч нь зөөлөн хүчний бүрэлдэхүүн хэсэг боловч үндсэн элемент биш. Улс төрийн хүчний өсөлт нь соёлын хүчийг хөгжүүлэхэд нөлөөлөх ч соёлын хүчний өсөлт улс төрийн хүч өсөхөд нөлөөлж чадахгүй. Тийм ч учраас түүхэнд өндөр соёлтой их гүрнүүд мөхөж байсан*”<sup>5</sup> хэмээн түүхэнд алдартай томоохон соёл иргэншлүүдийн жишээгээр тайлбарласан байдаг. Хятадын удирдагчид зөөлөн хүчний бодлогод соёлыг чухалчлах талыг бодлого болгон авч “Соёлын зөөлөн хүч” (文化软实力) гэсэн нэр томъёог хэрэглэж байна. Гэхдээ нөгөө хоёр эх сурвалжийг огт ашиглахгүй байх бус соёлыг тэргүүн эгнээнд тавина гэсэн үг. БНХАУ-ын “*XIV таван жилийн төлөвлөгөөний соёлыг хөгжүүлэх*” хэсэгт “*Соёл бол хамгийн чухал зөөлөн хүч, улс орны соёлын зөөлөн хүч ба Хятадын соёлын нөлөөлөх чадавхыг*

<sup>3</sup> Bonnie S.Glaser, Melissa E.Murphy, “Soft power with Chinese characteristics: the ongoing debate”, in *Chinese soft power and its implications for the United States. Competition and Cooperation in the developing world. A report of the CSIS Smart Power Initiative*, ed. Carola McGiffert (Center for Strategic and International Studies, 2009) P.12

<sup>4</sup> 王沪宁, “作为国家实力的文化: 软实力”, 复旦大学学报(社会科学版), 1993年第三版.

<sup>5</sup> 阎学通, “软实力的核心是政治实力”, 世纪行, 2007年6期. (原载《环球时报》2007年5月22日第12版)

нэмэгдүүлэх хэрэгтэй”<sup>6</sup> гэж заасан бол 2022 онд хуралдсан ХКН-ын ХХ их хурлын илтгэл дээр ч “Зөөлөн хүч” биш “Соёлын зөөлөн хүч” гэсэн нэр томъёо хэрэглэсэн байна. “Хятадын онцлогтой соёлын зөөлөн хүч” гэх ойлголтод Хятадын уламжлалт соёл ба Хятадын онцлогтой марксист соёлын тухай ойлголтыг багтаан үзэж байна.

- *Уламжлалт соёлын тухайд*: Соёлын тухай хамгийн түгээмэл тодорхойлолтод “Соёл гэдэг нь хүний зан үйлийн хэв маяг, шинж чанар хийгээд шашин шүтлэг, итгэл үнэмшил, нийгмийн хэм хэмжээ, урлаг, зан заншил, дадал зуршлаас хамаарах бүх зүйлийг хэлнэ” гэжээ. Соёлыг бүрдүүлдэг элементүүдийн хувьд Хятад өөрийн өвөрмөц онцлогтой. Угаас Хятадын уламжлалт соёл олон мянган жилийн түүхтэй дэлхийн эртний соёлуудын нэг ба шинж чанарын хувьд гадагш тархах бусад соёлуудыг өөртөө уусгах, нөлөөлөх чадвартай гэдгийг Япон, Солонгос, Зүүн өмнөд Азид үзүүлсэн нөлөөнөөс харж болно. Энэ тухай Х.Киссенжер “*үе үеийн хан үндэстэн Хатан голын хөндийгөөс аажмаар тэлж өргөжин хавь ойрынхоо үндэстэн ястныг хятад маягийн нийгэмдээ уусгаж байсан*”<sup>7</sup> гэж бичжээ. Хятадын уламжлалт соёлын энэ онцлог шинж нь зөөлөн хүчний үнэ цэнтэй эх сурвалж болдог. Үүнийг ойлгосон Хятадын

судлаачид, тухайлбал Хятадын Соёлын зөөлөн хүч судлалын төвийн дарга Жан Гуозуо (张国祚) “*Хятадын уламжлалт соёл бол манай соёлын зөөлөн хүчний үндэс суурь, давуу тал юм*”<sup>8</sup> гэж бичсэн. Нөгөө талаас соёлыг тээгч нь хүн байдаг. “Хятад хүний толгой дээр нар жаргадаггүй” гэдэг үг байдаг. Хятад үндэстэн дэлхийн өнцөг булан бүрд амьдардаг учир Хятад соёлыг түгээн дэлгэрүүлэх нөөц боломж ч их байна.

- *Хятадын онцлогтой марксист соёлын тухайд*: Хятад Улс уламжлалт Күнзийн суртал үнэт зүйлийг социалист үзэл санаатай уялдуулан Хятадын онцлогтой социалист хөгжлийн загвар бүтээж байна. Дотооддоо олон үндэстнүүд зэрэгцэн орших эв найрамдалтай нийгэм байгуулан өөрийн улсын ард иргэд төдийгүй дэлхийн нийтийн сонирхлыг татах, цаашлаад энэ хөгжлийн загвараа түгээн дэлгэрүүлэх, Хятадын хөгжлийн зам шилдэг болохыг батлан харуулах нь соёлын зөөлөн хүчийг бэхжүүлэх нэг арга зам гэж үзэж байна. Хятадын онцлогтой социализм байгуулж буй явцын талаар “*Ши Жиньпиний шинэ эриний Хятадын онцлогтой социализмын үзэл санаагаар удирдуулснаар нам болон улс орны үйл хэрэг түүхэн амжилтад хүрч байна. Тухайлбал,*

6 “中共中央办公厅 国务院办公厅印发 “十四五” 文化发展规划”， 2022年08月1日6, [http://www.gov.cn/zhengce/2022-08/16/content\\_5705612.htm](http://www.gov.cn/zhengce/2022-08/16/content_5705612.htm)

7 Хэнри Киссенжер, “Хятад”, Нэпко хэвлэлийн газар, 2011. 12-13-р тал.

8 张国祚, “中国软实力的特色与力量”, 人民日报, 2015年3月16日, 第016版.

эдийн засгийн хөгжлийн хурдаараа дэлхий нийтийн анхаарлыг татаж, үндэсний эдийн засаг дэлхийн эдийн засгийн 18.5 хувьд хүрч дэлхийн хоёр дахь том эдийн засаг болж, 100 сая орчим хөдөөгийн хүн амыг ядуурлаас гаргаж, ногоон хөгжлийн салбарт томоохон амжилт гаргаад байна”<sup>9</sup> гэж мэдээлжээ. Эдгээр үр дүндээ тулгуурлан Хятадын хөгжлийн загварын хүрсэн амжилтыг сурталчлах ажил зөөлөн хүчний бодлого үйл ажиллагаанд багагүй байр суурь эзлэх болсон.

Хятад Улсын соёлын зөөлөн хүчний бодлогын зорилгын талаар ХКН-ын XVIII удаагийн ТХ-ны УТТ-ны нэгдсэн сургалтын XII хуралдааныг даргалж БНХАУ-ын дарга Ши Жиньпиний хэлсэн үг”<sup>10</sup>-ийг багцлан харвал:

- Түүх нь гүн зузаан, үлэмж арвин
- Олон үндэстэн нь олон ургалч нэгдэлтэй

- Олон ургалч соёл нь эе зохиролтой
- Улс төр нь тунгалаг
- Эдийн засаг нь хөгжсөн
- Нийгэм нь тогтвортой
- Энх тайванч хөгжлийг баримталдаг
- Олон улсын тэгш эрх шударга ёсны төлөө байдаг
- Хүн төрөлхтний төлөө хувь нэмэр оруулдаг хариуцлагатай их гүрэн
- Нээлттэй, татах хүчтэй, итгэл найдвар, амьдрал эрч хүчээр дүүрэн социалист их гүрний дүр төрхийг илтгэн харуулья гэжээ.

Хятад Улс уламжлалт соёлоор дэлхий нийтийн анхаарлыг татахаас гадна улс төр засаглалын хэлбэрээ сурталчлах, олон улсын тавцанд Хятадын дуу хоолой байр суурийг хүчтэй болгох, олон улсын харилцаанд Хятадын онцлогтой элементийг оруулан Социалист соёлын их гүрэн болох зэрэг зорилго харагдаж байна.

### **“Соёлын гадагш гарах” стратеги: хэлний боловсрол, хэвлэл мэдээлэл, кино урлагийн салбарт:**

Соёлын зөөлөн хүчний бодлогыг бодитоор хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Соёлын дипломат ажиллагаа болдог. Хятад Улсын соёлын дипломат ажиллагааны гол цөм нь “Соёлын гадагш гарах” стратеги болно. “Гадагш гарах стратеги”-аас салбарласан “Соёлын гадагш гарах” стратегийн

үзэл санааг 2002 онд тухайн үеийн Соёлын сайд асан Сүн Жяжэн (孙家正) гарган тавьж, ХКН-ын XVI их хурлын 4-р бүгд хурал ба XI таван жилийн төлөвлөгөөнд оруулсан ажээ. Соёлын яамнаас 2004 онд “Арилжааны тоглолт, үзэсгэлэн яармаг зохион байгуулах, соёлын бүтээгдэхүүний

<sup>9</sup> Цай Вэньруй, “ХКН-ын XX их хурал Хятадын онцлогтой социализмд шинэ ялалтыг авчирч чадна”, *Өнөөгийн Хятад сэтгүүл*, 17-7(2022), 17-р тал.

<sup>10</sup> Ши Жиньпин, “Төр улсыг засах тухай”, Адмон хэвлэлийн газар, 2018, 210-р тал.

экспортыг дэмжих тухай мэдэгдэл”, Төрийн Зөвлөлөөс 2005 онд “Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортлох ажлыг сайжруулах өөрчлөх тухай санал” зэрэг дараалсан баримт бичиг гарсан. “Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортлох ажлыг сайжруулах өөрчлөх тухай санал”<sup>11</sup>-д “Хятадын соёлыг дэлгэрүүлэн олон улсын нөлөөг өргөжүүлж, соёлын аж үйлдвэрлэл хөгжиж байгаа ч манай орны соёлын баялаг нөөц, соёлын зах зээлийг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлж, ашиглаагүй, экспортод гаргаж буй соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо бага хэвээр, зах зээлийн өрсөлдөх чадвар харьцангуй сул байгааг харгалзан Хятадын уламжлалт шилдэг соёл, орчин үеийн соёлын ололт амжилт, Хятад соёлын олон улсын нөлөөг сурталчлах ойлгуулах ажилд хэвлэл мэдээлэл, радио, телевиз, соёл урлаг, спортын зэрэг салбарын соёлын бүтээгдэхүүн, соёлын үйлчилгээ бүгд багтана” гэж заасан байдаг. “Соёлын гадагш гарах” стратеги эхлээд соёлын бүтээгдэхүүн үйлчилгээг гадаадад

худалдан борлуулах чиглэлийн бодлого байсан бол одоо гадаад харилцаа, гадаад худалдаа, шинжлэх ухаан технологи, аялал жуулчлал, спорт, хэвлэл мэдээлэл, боловсрол, урлаг соёлын зэрэг салбартай хосолсон гадаад соёлын солилцооны нэгдсэн бодлого болоод байна.

“Соёлын гадагш гарах” стратегийн үйл ажиллагаанд хятад хэлийг түгээн дэлгэрүүлэх, тив дэлхийн хэмжээний арга хэмжээ зохион байгуулах (өвөл зуны олимп, дэлхийн экспо), хэвлэл мэдээлэл ашиглах, урлагийн тоглолт, эрдэмтэн судлаач солилцоо, үзэсгэлэн яармаг зэрэг бүхий л арга хэмжээг ашиглаж байна. Тэр дундаа хятад хэлний боловсрол, хэвлэл мэдээлэл, кино урлагийн салбарт их хэмжээний хөрөнгө зарцуулан өргөн далайцтай ажиллаж байна. Иймд эдгээр салбарын арга хэмжээний талаар болон Монгол Улс дахь Хятадын соёлын зөөлөн хүчний бодлогын хэрэгжилтийн байдлыг дээрх гурван салбарын хүрээнд авч үзье.

### Хятад хэлний боловсролыг дэлгэрүүлэх талаар:

Хэл, бичиг үсэг бол аливаа соёлын цөм учир үндэсний хэл, бичиг үсгийг дэлгэрүүлэх нь зөөлөн хүчийг бий болгоход чухал үүрэгтэй байдаг. Энэ ч утгаараа БНХАУ хятад хэлний боловсролыг дэлгэрүүлэх ажлыг чухалчилж байна. Дэлхий даяар хятад хэл сурах, Хятадад очиж суралцах хүсэлтэй оюутан сурагчид маш их

байдаг тэднийг дэмжих олон тооны хөтөлбөр, тэтгэлгүүд байдаг. “2018 онд БНХАУ-д 196 улс, бүс нутгаас ирсэн 492.185 оюутан 31 хот, мужийн 1004 сургуульд суралцаж байна. Үүнээс Засгийн газрын тэтгэлгээр 63000 оюутан буюу нийт суралцагчдын 12.81% сурч байна”<sup>12</sup>.

<sup>11</sup> “关于进一步加强和改进文化产品和服务出口工作的意见” 中共中央办公厅，国务院 办公厅。2005年11月19日

<sup>12</sup> 教育部，“2018年来华留学统计”，2019.04.12, [http://www.moe.gov.cn/jyb\\_xwfb/gzdt\\_gzdt/s5987/201904/t20190412\\_377692.html](http://www.moe.gov.cn/jyb_xwfb/gzdt_gzdt/s5987/201904/t20190412_377692.html)



Монгол Улсын хувьд БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлгээр жилд 220 орчим, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Засгийн ордны тэтгэлгээр жилд 100 орчим оюутан сургадаг ба Тусгай тэтгэлэгт хөтөлбөрөөр 2015-2019 оноос жилд 200 оюутан сургасан. 2018 оны байдлаар Хятадын их, дээд сургуульд суралцаж буй монгол оюутнуудын тоо 10158-д<sup>13</sup> хүрээд байсан бол “2021-2022 оны хичээлийн жилд Хятадын Их, дээд сургуулиудад нийт 6403 оюутан суралцаж байгаагаас 2228 нь БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байна”<sup>14</sup>. Хятадад суралцаж

буй оюутны тоо буурсан нь Ковид-19-ийн нөлөө ба нөгөө талаар Хятадын Засгийн газрын тэтгэлгийн шалгуур өндөр болсонтой холбоотой байна.

Манай эцэг эхчүүд хүүхдээ хятад хэл сургах сонирхол ч их байдаг. Энэ хэрэгцээ шаардлагад үндэслэн хятад хэлний сургалт явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн сургуулиуд олон байна.

Хятад Улсын зөөлөн хүчний нэг чухал арга хэрэгсэл нь дэлхий даяар хятад хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилготой Күнзийн институт болно. Күнзийн институт нь гадаад

*Хятад хэлний сургалттай дунд сургуулиуд<sup>15</sup>:*

Хувийн хэвшлийн хятад хэлний дунд сургуулиуд	Юй цай, Найрамдал, Дархан, Цайхун, Хишиг, Путунхуа, Хүслийн өргөө, Эрдэнэт Цайхун гэгээ, Шөнлижө, Күнз, Гэгээ, (хятад, англи) Орчлон Атланта
Хятад хэлийг сонгон суралцдаг улсын дунд сургуулиуд	15, 18, 23, 44, 50, 52, Монгени
Хувийн хэвшлийн хятад хэлийг сонгон суралцдаг сургуулиуд	Тольг, Орхон Хасу, Гёте, Эхлэл, Сэлбэ, Билиг, Улаанбаатар лицей, Шилдэг, Шинэ эхлэл, Их засаг, Орчлон, Оюунлаг, Амжилт, English School of Mongolia

*Хятад хэлний сургалттай их дээд сургуулиуд<sup>16</sup>:*

Төрийн их дээд сургууль	МУИС, МУБИС, ШУТИС, Улаанбаатар их сургууль, Ховд ИС, Дорнод ИС	Хятад хэл орон судлал, Хятад хэлний багш орчуулагч
Хувийн хэвшлийн их дээд сургууль	Хүмүүнлэгийн ухааны ИС, Отгонтэнгэр ИС, СЭЗИС, МҮИС, Сити дээд сургууль, Монгол-Хятадын хамтарсан ОУ-ийн дээд сургууль	Хятад хэлний орчуулагч

<sup>13</sup> Мөн тэнд

<sup>14</sup> Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ, “Боловсрол, соёл, шинжлэх ухааны харилцаа”, 2022.12.28, <https://beijing.embassy.mn/page/346>

<sup>15</sup> БНОУХ, “Монголын олон нийтийн болон мэдээллийн орон зай дахь БНХАУ-ын нөлөөллийг тодруулах судалгаа”-ны тайлан, УБ., 2023.

<sup>16</sup> Мөн тэнд

улс орнуудад хятад хэл заах, хятад хэлний багш бэлтгэх, сургалтын нөөц хэрэглэгдэхүүнээр хангах, хятад хэлний түвшин тогтоох шалгалт авах, Хятадын боловсрол, соёлын талаар мэдээлэл өгөх, Хятад болон гадаад хэл, соёлын солилцооны үйл ажиллагаа явуулдаг байгууллага ба тоо хэмжээгээрээ дэлхийд тэргүүлэхүйц хэл, соёлын байгууллага болоод байна.<sup>17</sup>

Монголд 2007 онд МУИС-ийн дэргэд, 2015 онд МУБИС, Ховд их

сургууль дээр Күнзийн институт байгуулагдсан. Күнзийн институтээс мөн өөрийн харьяанд Күнзийн танхим байгуулдаг. Монголд ажиллаж байгаа Күнзийн институтүүдийн үйл ажиллагаа тогтмолжиж, МУИС-ийн Күнзийн институтийн Монгол талын захирал М.Чимидцэеэ “Дэлхийн Күнзийн Институтийн тэргүүлэгч хүн” шагналыг хоёр удаа, МУИС-ийн Күнзийн институт “Дэлхийн дэвшилтэт Күнзийн институт” шагналыг хоёр удаа хүртжээ.<sup>18</sup>

### Хэвлэл мэдээллийн гадагш гарах стратеги:

Сүүлийн жилүүдэд Хятадын төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын өргөжин тэлэлт, эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгслийг зөөлөн хүчний бодлогодоо ашиглаж буй байдал нь дэлхий нийтийн анхаарлыг татах болсон. 2009 онд “2009-2020 онд Хятад Улсын төрийн хэвлэл мэдээллийг олон улсын түвшинд хүргэх ерөнхий төлөвлөгөө” гаргаж, тус салбарт 6 тэрбум орчим ам.долларын<sup>19</sup> санхүүжилт олгохоо зарласан. “Хэвлэл мэдээллийн гадагш гарах” стратеги хэрэгжүүлснээр:

- Хятадын улс төрийн тогтолцоо, бодлогыг дэлхий дахинд ойлгуулах
- Дэлхийн хэмжээнд болж буй асуудал, үйл явдлын талаар

Хятадын өөрийн хувилбарыг гарган мэдээлэх, олон улсын тавцанд үзэл бодлоо илэрхийлэх

- Хэвлэл мэдээллийн салбар дахь Англи-Америкийн монополь байдлыг эвдэх
- Олон улсын хамтын нийгэмлэгийн найдвартай, хариуцлагатай гишүүн, дэлхийн энх тайвныг тогтооход хувь нэмрээ оруулах хүсэлтэй, чадвартай улс болохоо харуулах.
- Худалдааны салбарт тогтвортой, найдвартай, хариуцлагатай түнш болохоо харуулах
- Эртний түүх, уламжлалт соёлоо сурталчлах зэрэг зорилтууд тавьжээ.

<sup>17</sup> 2019 оны 12-р сарын байдлаар дэлхийн 162 улс орон, бүс нутагт 550 институт, 1172 Күнзийн танхим байгуулагдаад байна. ( “全球孔子学院达550所” , 人民日报海外版, 2019年12月10日 第03版)

<sup>18</sup> “蒙古国立大学孔子学院蒙方院长其米德策耶翻译中国经典、促进文化交流获得多项奖励——“这是中国实施改革开放给我带来的机遇” , 人民日报, 2019年02月15日 17 版.

<sup>19</sup> Danielly Silva Ramos Becard, Paulo Menechelli Filho, “Chinese Cultural Diplomacy: instruments in China’s strategy for international insertion in the 21st Century”, *Revista Brasileira de Política Internacional*, 62(1): e005, 2019. DOI: <https://doi.org/10.1590/0034-7329201900105>



“Хэвлэл мэдээллийн гадагш гарах” стратегийг “造船出海” (Өөрийн завиа бүтээж (үйлдвэрлэж) далайд гарах”), “借船出海” (Завь зээлж далайд гарах) гэсэн хоёр арга замаар хэрэгжүүлж байна.

**“Өөрийн завиа бүтээж (үйлдвэрлэж) далайд гарах” (造船出海)** гэдэг нь дэлхийг хамарсан хэвлэл мэдээллийн сүлжээ байгуулж түүгээрээ мэдээлэл дамжуулах арга болно. Синьхуа агентлаг, Хятадын төв телевиз, Хятадын Олон улсын радио, Хятадын өдрийн сонин/Глобал Таймс сонины санхүүжилт өсөж, үйл ажиллагааны тэлэлт, дэд бүтцийн хангамжаар тэргүүлж дэлхийн 98%-ийг хамарсан хиймэл дагуулын сүлжээгээр<sup>20</sup> 24 цагийн турш мэдээлэл цацаж байна.

Синьхуа агентлаг гадаадад 180 төлөөлөгчийн газартай, 3 мянга гаруй сурвалжлагч, орон нутгийн ажилчидтай, 8 хэлээр (хятад, англи, франц, орос, испани, араб, португал, япон хэлээр) 24 цагийн турш текст, зураг, график, аудио, видео зэрэг бүх төрлийн мэдээ, мэдээллийг хэрэглэгчдэд хүргэж байна.

Хятадын Төв Телевиз (CCTV) - 171 улсад 6 сувгаар (хоёр нь англи, араб, франц, испани, орос хэлээр) цацагдаж байна. 2016 оны 12-р сард нэрээ Хятадын Глобал Телевизийн Сүлжээ (CGTN) болгон өөрчилсөн.

Хятадын Олон Улсын Радио (CRI) нь 65 хэлээр нэвтрүүлэг цацдаг.

China Daily/Global Times- China Daily сонин Хятадын нутаг дэвсгэр дээр хэвлэгдэхээс гадна Хонконг, АНУ, Канад, Европ, Ази, Африк, Латин Америкт хэвлэгддэг. Global Times

сонин нь Ардын өдрийн сонины Олон улсын мэдээний хятад хэлээр гардаг сонин байсан бол 2009 оноос англи хэл дээр гарч эхлэн дэлхий дахинд болж үйл явдлын талаар Хятад өөрийн байр суурийг илэрхийлэх гол хэрэгсэл болоод байна.

**Завь зээлж далайд гарах (借船出海)** – Гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан мэдээлэл дамжуулах арга зам. Ингэхдээ хамтран ажиллах, мэдээлэл хуваалцах ба бусад түншлэлийн гэрээ байгуулах мөн нийгмийн сүлжээний платформуудыг ашиглаж байна. (Жишээ нь: CCTV гадаадын 70 орчим хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох гэрээтэй, Хятадын өдрийн сонин Вашингтон Пост, Лос Анжелес Таймс, Daily Telegraph зэрэг сонинуудад сар бүр нэмэлт нийтлэл гаргадаг)

Хятад Улс уламжлалт хэвлэл мэдээлэлд түшиглэж “Гадагш гарч” байгаа ч эдгээр агентлагууд бүгд веб сайт ажиллуулах, нийгмийн сүлжээнд албан ёсны аккаунт нээн мэдээлэл дамжуулах зэргээр уламжлалт бус хэвлэл мэдээллийг ч өргөнөөр ашиглаж байна. Хятадыг гадаадад сурталчлахад зориулсан веб сайтууд нь олон хэлээр тодорхой сэдэвтэй, зорилтот бүс нутгуудад зориулсан өөр өөр загвартай бөгөөд Хятад Улсыг сурталчлах шинэ хэрэгсэл болж байна. (china.org.cn, china-pictorial.com.cn, chinatoday.com гэх мэт)

**“Хэвлэл мэдээллийн гадагш гарах” стратеги Монгол Улсад:** Монгол Улсад дэлхийн 14 хэвлэл мэдээллийн агентлагийн 21 сурвалжлагч, зураглаачид үйл ажиллагаа явуулж байна<sup>21</sup>.

<sup>20</sup> Zhang Xiaoling, “Chinese State Media Going Global”, *East Asia Policy*, 2, 42-50. 2017. [https://research.nus.edu.sg/eai/wp-content/uploads/sites/2/2017/11/Vol2No1\\_ZhangXiaoling.pdf](https://research.nus.edu.sg/eai/wp-content/uploads/sites/2/2017/11/Vol2No1_ZhangXiaoling.pdf)

<sup>21</sup> “Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Гадаадын хэвлэл мэдээллийн төлөөлөгчидтэй уулзав”, *МУ-ын Гадаад харилцааны яамны мэдээ*. <https://mfa.gov.mn/66051>

Үүнийг задалж харвал:

ОХУ	Mongolnow.com
БНХАУ	- Синьхуа - Хятадын Ардын өдрийн сонин - Хятадын төв радио - CCTV
Япон	- Асахи Шимбүн - Киодо Цүүшин - Фүжи телевиз
Их Британи	Reuters
Герман	bne Intellinews
Франц	Agency France Press
АНУ	Associated Press
БНСУ	KBS
Катар	Al Jazeera

Хүснэгтээс харахад Хятадын Big-4 гэгддэг Синьхуа агентлаг, Ардын өдрийн сонин, Хятадын төв радио, CCTV-гийн сурвалжлагч Монголд ажиллаж байна. Хятадын хэвлэл мэдээллийн байгууллагууд Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан мэдээллээ цацах ажиллагааг хийсээр ирсэн. Энэ тухай хэд хэдэн жишээг дурдаж болно. Үүнд: Мэдээллийн томоохон сайт news.mn дээр CCTV-гийн мэдээллийн тусгай булан ажилладаг, Хятадын сонгодог уран зохиол болох “Баруунш зорчсон үлгэр”, “Сүн улсын хүйтэн уулын бичиг”, “Улаан асрын зүүд”, “Гурван улсын үлгэр” зэргийг орчуулан Монголын томоохон сонин, цахим хуудас, радиогоор дамжуулах<sup>22</sup> зэрэг.

2013 онд хоёр улс “Монгол,

Хятадын стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр”-ийг баталсан. Энэ хөтөлбөрт Хэвлэл мэдээллийн байгууллагуудын солилцооны талаар маш тодорхой заалтууд орсон. Мөн үүний дараа 2014 оны 8 дугаар сард БНХАУ-ын дарга Ши Жиньпин Монгол Улсад төрийн айлчлал хийх үед хэлсэн үгэндээ “Хэвлэл, мэдээллийн салбарын тогтмол солилцоог бэхжүүлж, ингэснээрээ нийгэмд таатай уур амьсгалыг бүрдүүлж, Хятад, Монголын найрамдлыг эрчимтэй сурталчлахаар тохиролцсон... 250 сэтгүүлчийг Хятадад айлчлахыг урьж байна”<sup>23</sup> гэсэн. Эдгээр үйл явдлаас хойш Монгол-Хятадын хэвлэл мэдээллийн салбарын харилцаа, хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж иржээ. 2015-2019 оны хооронд

<sup>22</sup> “БНХАУ-аас МУ-д суугаа Элчин сайдын яамны 2017 онд хийсэн ажлын онцлох 10 үйл явдал”, [http://mn.china-embassy.gov.cn/mn/zmgx/201801/t20180103\\_1661707.htm](http://mn.china-embassy.gov.cn/mn/zmgx/201801/t20180103_1661707.htm)

<sup>23</sup> “БНХАУ-ын дарга Ши Жиньпин 2014 оны 8-р сард МУ-д айлчлах үед УИХ-ын хүндэтгэлийн чуулган дээр хэлсэн үг”, 2014.08.25, <https://ikon.mn/n/9pb>

жил бүр Монголын хэвлэл, мэдээллийн байгууллагын 50 төлөөлөгч Хятадад айлчилдаг уламжлал тогтож нийт 245 сэтгүүлч айлчилжээ. Тэд Хятад Улсын хот суурин, хөдөө орон нутгийн өөрчлөлт шинэчлэлт, өндөр технологийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлж буй байдал, ядуурлаас ангижрах бодлого, ногоон хөгжлийн бодлого үр дүнтэй танилцсан байна.

“Монгол-Хятадын стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр”-ийн дагуу хоёр орны харилцаанд уламжлал болсон нэгэн үйл ажиллагаа болох Монгол-Хятадын Хэвлэл мэдээллийн форум 14 дахь жилдээ зохион байгуулагдаад байна. Форумын үеэр хамтын ажиллагааны чиглэл, ирээдүйгээ дүгнэн ярилцдаг ба хоёр орны хэвлэл мэдээллийн байгууллагууд ээлж дараалан хамтран ажиллах, мэдээлэл солилцох санамж бичигт гарын үсэг зурдаг. 2021 онд болсон XII форумын үеэр МСНЭ-ийн Ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Борбилмаа *“Хятадын гадаад сурталчилгааны суваг, монгол хэлээрх мэдээ мэдээллийн суваг, нийгмийн сүлжээнд идэвхтэй нэвтэрч байна. Монголын чөлөөт хэвлэл, хэвлэн нийтлэх эрх чөлөө, нийгмийн сүлжээний үнэгүй платформууд үүнд өргөн боломж олгож байгаа. Харин Хятадын эрх зүйн орчин манайхаас өөр. Тэнд Монголын талаарх мэдээлэл, оюуны бүтээл, соёлын контент, бизнес эрхлэгчдийн сурталчилгааг нэвтрүүлэх босго өндөр. Тиймээс хамтын ажиллагаагаа энэ чиглэлд хөгжүүлэх шаардлагатай байна”*<sup>24</sup> гэж илтгэлдээ онцолсон нь

хоёр орны хэвлэл мэдээллийн салбарын хамтын ажиллагаанд буй асуудлыг гаргаж тавьжээ.

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслээр Хятад Улсын талаарх мэдээлэл маш их байдаг ч эдгээр мэдээллийн ерөнхий агуулга, хандлагыг анхаарах шаардлага гарч байгаа. Бид 2022 оны эхээр Ковид-19 цар тахлын үеэр БНХАУ-ын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Монголын голлох мэдээллийн сайтууд eagle.mn, news.mn, ikon.mn, gogo.mn, montsame.mn, bloombergtv.mn сайтуудын мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн юм. Ингэхэд манай мэдээллийн хэрэгслүүд гадаадын мэдээллийн агентлагуудыг мэдээллийн эх сурвалжаа болгодог мэдээг орчуулж редакцийн санал дүгнэлт бичилгүй талуудын байр суурийг мэдээлэлд орхисон байна. Эдгээр сайтад Хятадын Засгийн газраас ковидтой тэмцэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг шүүмжилсэн мэдээ байхгүй, эмч сувилагч нарыг дэмжиж хүндэтгэсэн, богино хугацаанд ковидын тархалтыг барьж, эдийн засгаа сэргээж чадсан Хятадын туршлагын тухай өгүүлсэн нийтлэлүүд байна. Хятад вакцины чанарт эргэлзэх, ковидыг Хятадаас гаралтай гэж үзэх зэрэг таагүй сэтгэгдлүүд нийгмийн сүлжээн дээр харагддаг боловч албан ёсны мэдээллийн сайтууд иймэрхүү мэдээлэл нийтэлдэггүй ажээ. Эндээс манай хэвлэл мэдээллээр тухайн улсын талаар сөрөг мэдээлэл гардаггүй болох нь харагдаж байна.

<sup>24</sup> “Монгол, Хятадын хэвлэл мэдээллийн 12 дугаар форум боллоо”, 2021.11.24, <https://montsame.mn/mn/read/282170>

## Хятадын кино гадагш гарах стратеги:

Кино, телевизийн бүтээл нь тухайн улсын соёлын үзэл баримтлал, нийгмийн статусыг агуулсан байдаг тул соёлын сурталчилгааны чухал хэрэгсэл болдог. 2010 оны эхээр Төрийн Зөвлөлөөс “Кино үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлэх тухай удирдамж санал” гаргаж Кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх, олон улсын нөлөө, өрсөлдөх чадвар, зах зээлд эзлэх хувийг дээшлүүлэх, кино урлагаар дамжуулж соёлын сурталчилгаа хийх “Хятадын кино Гадагш гарах” стратегийг хэрэгжүүлж эхэлсэн. “Хятадын кино гадагш гарах” стратегийн дагуу Хятадын кино үйлдвэрлэл, кино зах зээл өргөжин хөгжиж дэлхийн зах зээлд гарч байна. Гэвч нэг асуудал байдаг нь дэлхийн зах зээлд гарсан нэг болон олон ангит хятад кино төдийлөн амжилт олж чадахгүй байна. Өнгөрсөн хугацаанд дэлхийн зах зээл дээр гарсан Хятад кинонуудаас хамгийн их ашиг олсон “*Crouching Tiger, Hidden Dragon*” (卧虎藏龙) кино 205 сая ам.долларын<sup>25</sup> (1.3 тэрбум юань) ашиг олсон бол Хятадын зах зээлээс хамгийн их ашиг олсон “*Avengers: End game*” кино 4.2 тэрбум юанийн<sup>26</sup> ашиг олсон байна. Хятадын олон ангит киноны хувьд барууны үзэгчид төдий л сайн хүлээж авдаггүй ч Зүүн өмнөд Азийн орнуудад өндөр үзэлтэй байдаг.

Хятад кино дэлхийн зах зээлээс төдийлөн ашиг олдоггүй бол нөгөө талаас Холливудын кино үйлдвэрлэгчид Хятадын зах зээлээс маш их ашиг олдог. Хятад одоогоор дэлхийн хамгийн

олон кино театртэй улс болж, билет борлуулалтын орлогоороо нэгт орж эхэлсэн. Иймээс Холливудын кино үйлдвэрлэгчид Хятадын зах зээлд киногоо гаргах хүсэлтэй байдаг ч Хятадын Засгийн газраас жилд 34 гадаад киног гаргах эрх өгч агуулгын нарийн шалгуур тавьдаг. Холливудын студиуд энэ эрхийг авах, тэдний шалгуурт тэнцэхийн тулд хятад жүжигчдийг тоглуулах, Хятадад болж буй үзэгдэл оруулах, хятад хүнийг эсрэг дүрд тоглуулахгүй байх, Төвөд Шинжаан зэрэг улс төрийн асуудлыг хөндөхгүй байх, зарим киног хоёр хувилбараар хийх (Жишээ нь: Марвелийн Төмөр хүн-3 кино) мөн Хятадын кино студиудтэй хамтран ажиллах зэргээр бүхий л шаардлага, хязгаарлалтыг хүлээн авахад бэлэн байдаг. Энэ жишгээр хийгдсэн алдартай кино олныг дурдаж болно. (*Transformers: Age of Extinction*, *The Great Wall*, *Now You See Me 2*, *Shang-Chi and the Legend of the Ten Rings* гэх мэт) Холливудын зүгээс кино хийхдээ зах зээлийн зарчимд тулгуурлан ашиг олохыг чухалчилдаг бол Хятадын зүгээс гаднын зах зээлээс мөнгө олохоос илүүтэй сурталчилгааны хэрэгсэл болгон гадаад улстай хамтарсан кино хийх чиглэлийг илүү барьж байна. Энэ ч утгаараа “Хятадын Засгийн газраас 1.4 тэрбум хүнтэй зах зээлээ ашиглан Холливудын киног соёлын сурталчилгаанд ашиглах, хятадын соёлын элементийг зураг авалтад оролцуулах киноны агуулгыг хянах зэрэг эрх мэдэлтэй болж”<sup>27</sup> кино урлагийг

<sup>25</sup> “海外票房最高的十部华语电影：《功夫》上榜，《卧虎藏龙》第一”， 2021.01.11, <https://www.163.com/dy/article/G02O6OF70537RI6M.html>

<sup>26</sup> “内地总票房排名”， <https://www.endata.com.cn/BoxOffice/BO/History/Movie/Alltimedomestic.html>

<sup>27</sup> Danielly Silva Ramos Becard, Paulo Menechelli Filho, “Chinese Cultural Diplomacy:

зөөлөн хүчний бодлогодоо ашиглах болсон.

**Хятадын кино гадагш гарах стратеги Монгол Улсад:** БНХАУ-ын дарга Ши Жиньпин Монгол Улсад айлчлах үедээ “Хятадын шилдэг 25 олон ангит кино, телевизийн нэвтрүүлгийг үнэ төлбөргүй өгнө”<sup>28</sup> гэж мэдэгдэж байсны эхний кино “Бээжин хотын залуус” 2016 оны 6-р сарын 30-наас МҮОНТ-ийн I сувгаар гарч эхэлж байжээ. Тухайн үеийн БНХАУ-аас МУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шин Хаймины хэлснээр “Бээжингийн залуус” киноноос гадна нийт 25 олон ангит киног 5 жилийн турш Монголын төв ба олон нийтийн телевизээр гаргана<sup>29</sup> гэж мэдэгдэж байжээ. Энэ үеэс хойш Монголын телевизүүдээр Хятадын ОАК-нууд олноор гарах болсныг бид бүгд мэднэ. 2019 онд “Монголын 16 телевизээр Хятадын олон ангит 18 кино өдөр бүр хоёр удаагийн давтамжтайгаар гарч байна. Эдгээр кино нь олон ангит тул багадаа нэг сар түүнээс цааш хоёр, гурван сар үргэлжлэн гарна. Зарим кино нь нэг телевизээс нөгөөд дамжиж цацагдсаар хоёр жил шахам тасралтгүй үзэгчдэд хүрсэн нь ч бий”<sup>30</sup> гэсэн мэдээ гарч байжээ.

2019 оны 6-р сарын 26-ны өдрийн Синьхуа агентлагийн мэдээгээр “БНХАУ-ын ӨМӨЗО-ы Радио

Телевизийн Монгол хэлний сувгаас 2015 онд Улаанбаатар хотод халх монгол хэлний орчуулгын студи байгуулсан ба 2016 онд орчуулгын төв болж өргөжсөн. Одоогийн байдлаар 36 цуврал 1603 анги ОАК, 4 УСК орчуулснаас 30 цуврал 1346 анги ОАК, 2 УСК телевизээр цацагдаад байна. 2016 онд Улаанбаатар телевизээр гарсан Хөгийн хүргэн (大丈夫), Аав ээжийн хайр (父母爱情), Залуу нас (冰与火的青春) зэрэг киног дунджаар 100 мянган үзэгч үзсэнээс Хөгийн хүргэн киног 550 мянган хүн үзсэн нь МУ-ын гадаадын олон ангит кино үзэлтийн дээд амжилтыг тогтоожээ”<sup>31</sup> гэж Хятадын ОАК-ны амжилтын талаар мэдээлжээ.

Олон нийтийн санаа бодлын судалгаа, медиа тандалт, ТВ рейтингийн судалгааны “Максима Консалтинг” ХХК-ны “Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайлан”-гаас (2018, 2019, 2020) Монголын телевизүүдийн кино форматад Хятад киноны эзлэх хувийг харж болно. Мөн тус судалгааны хамгийн өндөр рейтингтэй кино төрөлд:

- 2018 онд 2-р байрт Оргил цаг-3, 5-р байрт Оргил цаг-1 УСК
- 2019 онд 5-р байрт Сүн Үкун ОАК
- 2020 онд 6-р байрт Шаолины хөл бөмбөг<sup>32</sup> УСК-нууд орсон байна.

instruments in China’s strategy for international insertion in the 21st Century”, *Revista Brasileira de Política Internacional*, 62(1): e005, 2019. DOI: <https://doi.org/10.1590/0034-7329201900105>


<sup>28</sup> “БНХАУ-ын дарга Ши Жиньпин 2014 оны 8-р сард МУ-д айлчлах үед УИХ-ын хүндэтгэлийн чуулган дээр хэлсэн үг”, 2014.08.25, <https://ikon.mn/n/9pb>.

<sup>29</sup> “Хятад киноны аян “Бээжингийн залуус”-аар эхэллээ”, 2016.07.03, <https://news.mn/r/738544/>

<sup>30</sup> “Дэлгэц эзэгнэсэн Хятад сериал”, 2019.09.09. <https://news.mn/r/2191541/>

<sup>31</sup> “中国电视剧走俏蒙古国”, 新华社, 乌兰巴托, 6月26日电通讯 [http://www.xinhuanet.com/world/2019-06/26/c\\_1124673598.htm](http://www.xinhuanet.com/world/2019-06/26/c_1124673598.htm)

<sup>32</sup> “Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайлан”, *Максима Консалтинг ХХК*,



*Эх сурвалж: Максима Консалтинг ХХК “Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайлан”  
(2018,2019,2020)*

Дээрх графикаас харахад Солонгосын ОАК-ны хувь хэмжээнд арай хүрэхгүй байгаа ч Хятад киноны эзлэх хувь жил ирэх бүр өссөөр мөн шилдэг рейтингтэй кинонд ОАК, УСК-нууд байр эзлэх болжээ.

Монголд гарч буй ОАК ба УСК-ны агуулгыг харахад:

- Түүхэн сэдэвтэй
- Хот суурин, хөдөө орон нутгийн өөрчлөлт шинэчлэлт, эгэл жирийн иргэдийн ахуй амьдрал
- Хөдөө тосгон иргэдийн ядуурлаас ангижирсан түүх
- Залуусын хайр дурлал, үнэнч сэтгэл, эр зориг, хүсэл мөрөөдөл, зөв хүмүүжил, хичээл зүтгэл
- Японыг эсэргүүцэх дайны сэдэвтэй эх оронч сэдэвтэй
- Шинжлэх ухаан технологийн дэвшлийг харуулсан

- COVID-19 цар тахалтай тэмцсэн тухай гэсэн өргөн сэдвийг хамарсан байна.

Монгол-Хятад хоёр орны соёлын солилцооны уламжлал болсон нэг арга хэмжээ бол кино өдөрлөг болно. Хятадын кино өдрүүд манай улсад илүү олон удаа зохион байгуулагддаг. Тухайн жилдээ ашиг орлогоор тэргүүлсэн болон сэдэв, агуулгын хувьд маш өндөр шалгуур тавьж кинонуудаа сонгодог байна.

2018-2023 оны хооронд Хятад Улс Монголд дөрвөн удаа кино өдрүүд зохион байгуулж 38-УСК, 3-ОАК гаргасан бол Монголоос Хятад Улсад нэг удаа дөрвөн УСК гаргажээ.

Хятадын кино “Гадагш гарах” стратегийн өөр нэгэн арга хэмжээ нь Хятадын олон улсын кино наадмын цар хүрээ, нэр хүндийг өсгөх байдаг. China Golden Rooster&Hundred

2018,2019,2020 он.



*Хоёр орны кино өдөрлөгөөр үзүүлсэн киноны тоо:*

	2018	2019	2020.12-2021.01	2023	Нийт
Монгол Улс	-	4	-	-	4-УСК
БНХАУ	10	11	11-УСК, 3-ОАК	6	38-УСК 3-ОАК

Flowers Film Festival, Бээжин, Шанхай, Хонконгийн олон улсын кино наадам зэрэг кино наадмуудын нэр хүнд өсөж оролцогчдын тоо ч нэмэгдсээр байна. Монголын кинонуудаас 2018 онд Шанхайн олон улсын XXI кино наадмын шилдгээр Монгол, Швейцарын хамтарсан “Out of paradise” кино шалгарч “Best Feature

Golden Goblet” шагнал хүртсэн байна. Мөн “Х-ТҮЦ” продакшны бүтээл “Солиот эх” кино 2019 оны 5-р сард Чэндү хотноо зохион байгуулагдсан Азийн киноны их наадмаас “шилдэг эмэгтэй гол дүр”, “шилдэг уран бүтээл”-ийн шагнал тус тус хүртэж байжээ.

### Дүгнэлт

Хятад орон хөгжин хүчирхэгжиж буй нь дэлхий нийтийн анхаарлыг татаж эхэлснээр энэ өсөлт хөгжлөөс айх болгоомжлох хандлага ч их болсон. Иймд Хятад Улсыг дэлхий дахинд илүү сайн ойлгуулж танин мэдүүлэх, Хятадын өсөлтөөс айх хэрэггүй гэдгийг сурталчлан ойлгуулах шаардлага байгааг ухаарч зөөлөн хүчний бодлого эрчимтэй явуулж эхэлсэн. Зөөлөн хүчний бодлогодоо юуг онцлох талаар Хятадын эрдэмтэн судлаачдын дунд онолын маргаан өрнөж байсны дараа “соёл”-ыг онцлон Хятадын зөөлөн хүчний гол эх сурвалж гэж үзэж, олон мянган жилийн түүхтэй өвөрмөц соёл болон Хятадын онцлогтой марксист соёлын үзэл санаа, ололт амжилтыг сурталчлахыг зөөлөн хүчний бодлогын онцлог болгон зарласан.

“Соёлын гадагш гарах” стратегийг анх соёлын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, соёлын солилцоог дэмжих

зорилготой гаргаж ирсэн бол одоо гадаад харилцаа, шинжлэх ухаан технологи, аялал жуулчлал, спорт, зээл тусламж, хэвлэл мэдээлэл зэрэг олон салбартай хосолсон соёлын солилцооны нэгдсэн бодлого болжээ.

Хятад Улс бодлогын тогтвортой байдал, санхүүгийн чадавхдаа тулгуурлан соёлын дипломат ажиллагааны бүхий л арга хэрэгслийг ашигладаг. Тэр дундаа хятад хэлний боловсрол, хэвлэл мэдээлэл, кино урлагийг соёлын сурталчилгаанд ашиглахад ихээхэн хөрөнгө зарцуулж өргөн далайцтай ажиллаж байна.

Хэл нь тухайн үндэстний соёлын суурь агуулгыг багтааж байдаг. Хятад хэлийг дэлхий дахинд түгээх ажлыг эрчимтэй хийж Күнзийн институтийн тэлэлтээр дэлхийд тэргүүлэхээс гадна хятад хэл сурах сонирхолтой гадаад хүмүүст олгодог тэтгэлгийн хэмжээ, төрөл зүйл өссөөр байна. Манай

улсын хувьд гурван Күнзийн институт ажиллаж байна. Хятад хэл сурах, Хятад Улсад очиж суралцах сонирхолтой оюутны тоо өссөөр, эцэг эхчүүд ч хүүхдээ хятад хэл сургах сонирхол их байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн дэлхийг хамарсан сүлжээ байгуулж, өөрийн дуу хоолойг олон хэлээр, олон хувилбараар дамжуулах, сурталчилгаа нөлөөллийн ажлыг өргөн хүрээнд хийдэг болсон. Манай улсад Хятадын төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн дөрвөн байгууллага ажиллаж байна. Монголын олон хэвлэл мэдээллийн байгууллага Хятадын мэдээллийн байгууллагуудтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах гэрээтэй ажиллан Хятадын талын мэдээллийг хүлээн авч түгээдэг ч эргээд Монгол Улсын талаарх мэдээллийг Хятадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргах, мэдээлэл солилцох тал дээр хойрго хандаж байна. Хоёр талын энэ салбарын хамтын ажиллагаа ихэнхдээ Хятадын талын санал санаачилга, санхүүжилтээр явагддаг, Монгол Улс идэвхгүй хүлээн авагчийн байр сууринаас ханддаг байдал харагдаж байна.

Кино урлагын салбарын хувьд Хятадын кино дэлхийн зах зээл дээр төдийлөн амжилт олдоггүй болох нь түүний олсон орлогоос харагдаж байна. Нөгөө талаас Холливудын

кино үйлдвэрлэгчид дэлхийн хамгийн том зах зээлд киногоо гаргахын тулд Хятадын зүгээс ирэх ямар ч саналыг хүлээн авахад бэлэн байснаар Холливудын blockbuster кинонуудын агуулгыг хянах, засвар хийх эрхтэй болж кино урлагийг соёлын зөөлөн хүчний бодлогодоо ашиглаж байна. Харин Монгол Улсад ОАК-гоор дамжуулан Хятад орныг, соёлоо сурталчлах тал нь илүү байна. Дээр өгүүлсэнчлэн Хятадын ОАК-нууд нь үнэгүй байдаг учир Монголын телевизүүд агуулгын шалгуур хяналт тавилгүй шууд цацдаг үзэгдэл түгээмэл байна. Хятад киноноос эгэл жирийн иргэдийн ахуй амьдрал, зөв хүмүүжил, хичээл зүтгэл, өндөр ёсзүй, ажлын хариуцлага, шинжлэх ухаан технологийн дэвшил зэрэг зүйлийг харж болох ч зарим түүхэн киноны агуулгыг анхаарч үзэх хэрэгтэй байдаг.

Хятад Улс их гүрэн болж зөөлөн хүчний бодлогыг дэлхий даяар явуулж байна. Монгол-Хятад хоёр улс найрамдалт харилцаатай хөрш орнууд учир Хятадын энэ бодлогоос зугтах, хориглох боломжгүй. Эцэст нь дүгнэхэд, бид улс орнууд Монгол Улсад зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлж байна гэж шүүмжлэх эсэргүүцэх биш харин түүнийг хүлээн авч, ойлгон танин мэдсэнээр зөвөөр ашиглах, энэ талаар бодлогын зөв шийдэл олох боломжтой.

## Ном зүй:

### Монгол хэлээр:

1. “БНХАУ-аас МУ-д суугаа Элчин сайдын яамны 2017 онд хийсэн ажлын онцлох 10 үйл явдал”, 2018.01.03, [http://mn.china-embassy.gov.cn/mn/zmgx/201801/t20180103\\_1661707.htm](http://mn.china-embassy.gov.cn/mn/zmgx/201801/t20180103_1661707.htm)
2. “БНХАУ-ын дарга Ши Жиньпин 2014 оны 8-р сард МУ-д айлчлах үед УИХ-ын хүндэтгэлийн чуулган дээр хэлсэн үг”, 2014.08.25, <https://ikon.mn/n/9pb>
3. Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, “Монголын олон нийтийн болон мэдээллийн орон зай дахь БНХАУ-ын нөлөөллийг тодруулах судалгаа”. *Судалгааны тайлан*. 2023.
4. “Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Гадаадын хэвлэл мэдээллийн төлөөлөгчидтэй уулзав”, 2021.12.22, <https://mfa.gov.mn/66051>
5. “Дэлгэц эзэгнэсэн Хятад сериал нийтлэл”, 2019.09.09, <https://news.mn/r/2191541/>
6. “Монгол, Хятадын хэвлэл мэдээллийн 12 дугаар форум боллоо”, 2021.11.24, <https://montsame.mn/mn/read/282170>
7. Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ, “Боловсрол, соёл, шинжлэх ухааны харилцаа”, 2022.12.28, <https://beijing.embassy.mn/page/346>
8. Стратеги судалгааны хүрээлэн, “Их гүрнүүдийн зөөлөн хүчний бодлого Монгол Улс”, *Аюулгүй байдал, стратеги тойм сэтгүүл*, №17, 2023/05
9. “Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайлан”, Максима Консалтинг ХХК, 2018, 2019, 2020.
10. Хэнри Киссенжер, “Хятад”, Нэпко хэвлэлийн газар, 2011.
11. “Хятад киноны аян “Бээжингийн залуус”-аар эхэллээ”, 2016.07.03, <https://news.mn/r/738544/>
12. Цай Вэньруй, “ХКН-ын ХХ их хурал Хятадын онцлогтой социализмд шинэ ялалтыг авчирч чадна”, *Өнөөгийн Хятад сэтгүүл*, 2022, Vol17, №7.
13. Ши Жиньпин, “Төр улсыг засах тухай”, Адмон хэвлэлийн газар, 2018.

### Хятад хэлээр:

1. “胡锦涛在中国共产党第十七次全国代表大会上的报告”, 2007年10月25日, <http://cpc.people.com.cn/> (ХКН-ын XVII их хурал дээр Ху Жиньтаогийн тавьсан илтгэл, 2007.10.25)
2. “中共中央办公厅, 国务院办公厅印发 “十四五”文化发展规划”, 2022年08月1日, [http://www.gov.cn/zhengce/2022-08/16/content\\_5705612.htm](http://www.gov.cn/zhengce/2022-08/16/content_5705612.htm) (“ХКН-ын Төв Хорооны ажлын алба, Төрийн Зөвлөлийн ажлын алба хэвлэв. “XIV таван жилийн төлөвлөгөө” Соёлыг хөгжүүлэх төлөвлөгөө”, 2022.08.11)

3. “关于进一步加强和改进文化产品和服务出口工作的意见”， 中共中央办公厅， 国务院办公厅. 2005年11月19日 (“Соёлын бүтээгдэхүүн үйлчилгээг экспортлох ажлыг сайжруулах өөрчлөх тухай санал”, ХКН-ын Төв хорооны ажлын алба, Төрийн Зөвлөлийн ажлын алба. 2005.11.19)
4. 王沪宁, “作为国家实力的文化: 软实力”, 复旦大学学报(社会科学版) 1993年第三版. (Ван Хунин, “Соёл” улс орны хүч чадал болох нь: Зөөлөн хүч”, Фудан их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл (Нийгмийн шинжлэх ухаан) 1993 он, 3-р улирал)
5. 阎学通, “软实力的核心是政治实力”, 世纪行, 2007年6期. (原载《环球时报》2007年5月22日第12版) (Янь Шюэтун, “Зөөлөн хүчний гол цөм бол улс төрийн хүч чадал”, Шыжишин сэтгүүл, 2007, 06 дугаар. Анх Global times сонины 2007 оны 5-р сарын 22-ны 12-р хэвлэл дээр нийтлэгдсэн)
6. 张国祚, “中国软实力的特色与力量”, 人民日报, 2015 年3 月16 日, 第 016 版 (Жан Гуозуо) “Хятадын зөөлөн хүчний онцлог ба хүч чадал”, Ардын өдрийн сонин, 2015.03.16, 16-р хэвлэл
7. 教育部, “2018年来华留学统计”, 2019.04.12, [http://www.moe.gov.cn/jyb\\_xwfb/gzdt\\_gzdt/s5987/201904/t20190412\\_377692.html](http://www.moe.gov.cn/jyb_xwfb/gzdt_gzdt/s5987/201904/t20190412_377692.html), (Хятадын Боловсролын яамны мэдээ, “2018 онд Хятад ирж сурсан оюутнуудын тоо статистик)
8. “中国影视剧走俏蒙古国”, 新华社, 乌兰巴托, 6月26日电通讯 [http://www.xinhuanet.com/world/2019-06/26/c\\_1124673598.htm](http://www.xinhuanet.com/world/2019-06/26/c_1124673598.htm) (Синьхуа агентлаг Улаанбаатар. 6-р сарын 26-ны цахилгаан мэдээ: Монгол Улсад Хятадын олон ангит кинонууд алдаршиж байна)
9. “全球孔子学院达550所”, 人民日报海外版, 2019年12月10日 第03版 (“Күнзийн институтийн тоо дэлхий даяар 550-д хүрлээ”, Ардын өдрийн сонины гадаад хэвлэл, 2019.12.10, 3-р хэвлэл)
10. “蒙古国立大学孔子学院蒙方院长其米德策耶翻译中国经典、促进文化交流获得多项奖励——“这是中国实施改革开放给我带来的机遇”, 人民日报, 2019年02月15日 17 版. (“МУИС-ийн Күнзийн институтийн Монгол талын захирал М.Чимэдцэеэ Хятадын сонгодог зохиолуудыг орчуулж, соёлын солилцоог дэмжсэн учраас олон удаа шагнал хүртэж байв – “Энэ бол Хятад улсын Өөрчлөлт шинэчлэлтийн бодлогын үр дүнд надад олдсон боломж”, Ардын өдрийн сонин, 2019.02.15. 17-р хэвлэл)
11. “海外票房最高的十部华语电影: 《功夫》上榜, 《卧虎藏龙》第一”, 2021.01.11, <https://www.163.com/dy/article/G02O6OF70537RI6M.html> (“Гадаад тасалбар борлуулалтаас хамгийн их орлого олсон Хятадын 10 кино”: “Кунфу” кино жагсаалтад орж ирж, “Гэтэж буй бар, нуугдаж буй луу” кино нэгдүгээрт жагсав”, 2021.01.11)
12. “内地总票房排名”(进口), <https://www.endata.com.cn/BoxOffice/BO/History/Movie/Alltimedomestic.html> (Хятад улсад тасалбар борлуулалтаар хамгийн их орлого олсон гадаад киноны жагсаалт)

**Англи хэлээр:**

1. Bonnie S.Glaser, Melissa E.Murphy, “Soft power with Chinese characteristics: the ongoing debate”, in *Chinese soft power and its implications for the United States. Competition and Cooperation in the developing world. A report of the CSIS Smart Power Initiative*, ed. Carola McGiffert (Center for Strategic and International Studies, 2009) P.12
2. Danielly Silva Ramos Becard, Paulo Menechelli Filho, “Chinese Cultural Diplomacy: instruments in China’s strategy for international insertion in the 21st Century”, *Revista Brasileira de Política Internacional* , 62(1): e005, 2019. DOI: <https://doi.org/10.1590/0034-7329201900105>
3. Zhang Xiaoling, “Chinese State Media Going Global”, *East Asia Policy*, 2, 42-50. 2017. [https://research.nus.edu.sg/eai/wp-content/uploads/sites/2/2017/11/Vol2No1\\_ZhangXiaoling.pdf](https://research.nus.edu.sg/eai/wp-content/uploads/sites/2/2017/11/Vol2No1_ZhangXiaoling.pdf)

## The impact of China’s soft power policy and Mongolia

***Khishigtuya Maksim***

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,*

*Ulaanbaatar, Mongolia*

*khishigtuya\_m@mas.ac.mn*

***Abstract:*** *As China's development and strength garnered global attention, other nations grew increasingly apprehensive of its growth. Consequently, the Chinese government has vigorously pursued a soft power policy to enhance global understanding and alleviate concerns about China's rise. The country places significant emphasis on its cultural aspects within its soft power policy, highlighting the promotion of its unique culture with a history spanning thousands of years, as well as the ideals and achievements of Chinese Marxist culture as key elements of its soft power strategy.*

*This article briefly touches upon the primary component of China's cultural soft power policy, known as the “Going global” strategy. It discusses the use of Chinese language education, media, and cinema as instrumental tools for cultural diplomacy, and how this policy is being implemented in Mongolia, within the context of the industry.*

***Keywords:*** *China, cultural soft power, going out policy, Chinese language, media, cinema*

<i>The day of submission:</i>	<i>2023.06.15</i>
<i>Completion of review:</i>	<i>2023.07.03</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2023.10.02</i>